

**“ТӨРӨӨС АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН  
ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
(2019 оны жилийн эцсийн байдлаар)

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.**

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус удирдлага болгон, төрөөс баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн 2019 оны жилийн эцсийн биелэлтэд үндэслэн гүйцэтгэв.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.**

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого /төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын дунд хугацааны стратеги/ 77.1 хувьтай хэрэгжиж байна.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан нийтлэг журмын дагуу салбарт хэрэгжиж буй төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцыг 2019 оны байдлаар гаргуулан авч үнэлгээг хийв.

**3.2. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт.**

Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолоор Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг баталсан. Тус бодлогыг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд 2015-2020 онд/ I үе шат/, 2020-2025 он /II үе шат/, 2025-2030 он /III үе шат/-уудад хэрэгжих ба Засгийн газрын 2015 оны 396 дугаар тогтоолоор “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги” /2015-2020/-ийг баталсан байна.

Тус бодлогыг үндсэн хэрэгжүүлэгч байгууллага нь Аж үйлдвэрийн яам /хуучнаар/ байсан бөгөөд яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай Засгийн газрын 2016 оны 3 дугаар тогтоолын дагуу хөнгөн үйлдвэрийн асуудал нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд, хүнд аж үйлдвэрийн асуудал нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд зарим бусад асуудал нь Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам, Үндэсний хөгжлийн газарт тус тус хамаарч байна.

**ТӨРӨӨС АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ЯВЦ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО**

Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо					Хэрэгжилт /хувь/
		100	70	40	0	ҮБ-гүй	
1. Үйлдвэрлэл, худалдааг дэмжсэн, үйлдвэрлэл, худалдаа эрхлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	8	4	1	1		2	85.0
2. Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, орон зайн горимыг тодорхойлж, үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоох, Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал боловсруулах, салбарын мэдээллийн тогтолцоог сайжруулах;	3	1	2				80.0

3. Бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тогтоон, үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратегийг боловсруулан, үйлдвэрийн /кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх;	6	2	1	3			65.0
4. Дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан боловсруулах, дахин боловсруулах үйлдвэрүүдийг санхүүгийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;	2	1	1				85.0
5. Мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх замаар бүтээлч аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, шинэ чадавх, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох;	1	1					100.0
6. Үйлдвэрлэлийн хүний нөөцийн эрэлтэд суурилсан ажиллах хүч бэлтгэж, тогтвор суурьшилтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.	4	1	3				77.5
<b>Дүн</b>	<b>24</b>	<b>10</b>	<b>8</b>	<b>4</b>		<b>2</b>	<b>82,1</b>

Дунд хугацааны стратегид тусгагдсан ХХААХҮ-ийн салбарт хамаарах 24 арга хэмжээний хэрэгжилт, бодлогын зорилтуудын 2019 оны жилийн эцсийн үр дүн 77.1 хувиар үнэлэгдэж байна.

Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэхээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2018 оны А-79/А/93 дугаар тушаалаар “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан байна. Уг төлөвлөгөө батлагдсанаар толгойлон хэрэгжүүлэх арга хэмжээнүүд тодорхой болсоны үр дүнд төлөвлөгдсөн зарим ажлууд эрчимжсэн байна.

#### **Дөрөв. Дүгнэлт.**

1. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг хүчингүй болсон, “Үйлдвэрлэлийг дэмжих сан”-г татан буулгасан хэдий ч үйлдвэрлэл, худалдааг дэмжих эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийг 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар, ЗГ-ын 2019 оны 156 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тэргүүлэх чиглэлийг ЗГ-ын 2019 оны 190 дүгээр тогтоолоор батлуулав. Мөн 418 дугаар тогтоолоор “Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр”, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийг 362 дугаар тогтоолоор батлуулж, хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр тодорхой ахиц гарсан байна. “Үйлдвэржилт 21:100”, “Ноолуур” хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь 33.3%, арвс ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 33.1%, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 26%-иар тус тус өссөн дүнтэй байна. Харин “Худалдааны тухай хууль”-ийг боловсруулж, батлуулах ажил удаашралтай байна.

2. “Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, орон зайн горимыг тодорхойлж, үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоох, Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал боловсруулах, салбарын мэдээллийн тогтолцоог сайжруулах зорилт”, “Дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан боловсруулах, дахин боловсруулах үйлдвэрүүдийг санхүүгийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилт”, “Мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх замаар бүтээлч аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, шинэ чадавх, бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох зорилт”-уудыг хэрэгжсэн хэмээн үзэж байна. Өмнөх

онтой харьцуулахад: Инновацийн шинэ төрлийн бүтээгдэхүүнүүд гарч, дотоод болон гадаадын орны захиалгыг авч, бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэж, экспортод гаргаж эхэлсэн бодитой үр дүнгүүд гарсан.

3. “Бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тогтоон, үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратегийг боловсруулан, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх зорилт”-ыг хэрэгжүүлэх 6 арга хэмжээнээс үйлдвэрийг кластераар хөгжүүлэх, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн. Харин хөнгөн аж үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтын ажил санхүү, хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдэхгүйгээс ажлын явц удаашралтай байна. Аж үйлдвэрийн тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

4. “Үйлдвэрлэлийн хүний нөөцийн эрэлтэд суурилсан ажиллах хүч бэлтгэж, тогтвор суурьшилтай ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилт”-ын хүрээнд “Мэргэжилтэй ажилтан хөтөлбөр”-ийг боловсруулж, батлуулах арга хэмжээ удаашралтай байгааг эрчимжүүлж, яаралтай батлуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

#### **Тав. Санал, зөвлөмж.**

1. Хөнгөн аж үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, улсын төсөв болон “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн жил бүрийн төсөвт тусгаж, батлуулах арга хэмжээг авах,

2. Аж үйлдвэрийн тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх,

3. “Мэргэжилтэй ажилтан хөтөлбөр”-ийг боловсруулж батлуулан, хэрэгжүүлэх,

4. Үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлж буй эхлэлийг улам өргөжүүлж, энэ чиглэлээр тодорхой бүтээлч арга хэмжээг авах, кластераар ажиллаж байгаа үйлдвэрүүдийг сурталчлах.

Бодлогын баримт бичгийн 2019 оны хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан, нэгтгэлийг хавсаргав.

**ТӨРӨӨС АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ДУНД ХУГАЦААНЫ  
СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Үндэслэж буй бодлогын баримт бичиг, зорилт	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл	Дэлгэрэнгүй тайлбар (хэрэгжээгүй шалтгаан)
				Он	Түвшин				
	4.1 Үйлдвэрлэл, худалдааг дэмжсэн, үйлдвэрлэл, худалдаа эрхлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	4.1.1 Худалдааг дэмжсэн хууль, эрх зүйн актыг шинээр боловсруулан баталж мөрдүүлэх	шинээр боловсруулсан хууль, эрх зүйн акт-1 хуулийн үзэл баримтлалын төсөл, судалгаа боловсруулсан байх	2016-2018	Худалдааны тухай хууль байхгүй.	Худалдааны тухай хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	Худалдааны тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулж, ДХБ-ын хэлэлцээрээр хүлээсэн үүрэг, амлалтыг хэрэгжүүлэх хүрээнд экспорт, импортын барааны тарифын болон тарифын бус зохицуулалтыг оновчтой хэрэглэх талаарх саналыг тусган хэлэлцүүлгийн шатанд ажиллаж байна. Хуулийн төсөлд дараах цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг тусгав. Үүнд: “Хэрэглэгчээ дээдэлсэн ХХААХҮ-ийн бодлого” сургалт семинарыг 21 аймаг, нийслэл, яамдын дэргэдэх хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах орон тооны бус зөвлөл, салбарын нийгэмлэгийн тэргүүн, гүйцэтгэх захирал, шинжээчдийн 90 төлөөлөл, “Худалдааны салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдэх гарц” хэлэлцүүлэгт худалдаа эрхлэгчид, ТББ, ахмадын 300 гаруй, “Худалдааны салбарын хууль, эрх зүйн орчинг сайжруулах” хэлэлцүүлэгт төрийн байгууллага, сургалт, судалгааны байгууллагын 50 гаруй, “Их хүрээ-2019” чуулганыг “МОРА” ТББ-тай	40	

							хамтран Төрийн ордонд зохион байгуулж, 800 гаруй хүнийг тус тус хамруулсан. Худалдааны тухай хуулийн төслийг Англи хэлэнд орчуулах ажлыг Европын Холбооны ТРАМ төслийн шугамаар гүйцэтгүүлэв.		
		4.1.2.Худалдааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлж, тарифын болон тарифын бус зохицуулалтыг олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэх	шинээр боловсруулсан хууль, эрх зүйн акт-1	2016-2020	Худалдааны талаар хууль, эрх зүйн зохицуулалт дутмаг	Хуулийн хэрэгжилттэй холбогдох журмын төслүүдийг боловсруулж, батлуулсан байна.	Хүнсний тухай хууль тогтоомжийн хүрээнд стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журмыг шинэчлэн ЗГ-ын 2019 оны 329 дүгээр тогтоолоор батлуулав. Дотоодын зах зээлийг хамгаалах, үйлдвэрлэлийг дэмжих ГХЯ-наас байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хамтран ажиллаж, Гадаад худалдааны хамгаалалтын арга хэмжээний эрх зүйн зохицуулалтын төслийг боловсруулсан. ДХБ-ны шугамаар гадаадын экспертийг урьж ирүүлэн холбогдох төрийн болон ТББ, ЭШБ-уудын төлөөллийг оролцуулсан семинарыг 2019.12. 10-11-нд зохион байгуулав. Тарифын зохицуулалтын хүрээнд зарим бараа бүтээгдэхүүний гаалийн тарифт өөрчлөлт оруулах талаар дотоодын үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадал, түүний ашиглалт, зах зээлд эзлэх хувь, чанар стандартын шаардлага хангасан байдал зэрэгтэй уялдуулан судалгааг авч байна. Холбогдох зохицуулалтын саналыг бэлтгэн Гаалийн тарифын зөвлөлд хүргүүлэхээр ажиллаж байна.	ҮБ-гүй	Хууль батлагдаагүй тул журам боловсруулах боломжгүй

		4.1.3.Татварын бодлогын талаар эрх зүйн орчныг сайжруулах.	Багц санал-1	2018	Татварын бодлогын үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдэд таатай бус	Татварын багц хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал тусгуулсан байна	Дотоодын худалдаа, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжсэн СЯ-наас боловсруулсан Татварын багц хуулийн шинэчлэлд санал өгч, тус хууль 2019 оны 03 сарын 22-ны өдөр УИХ-аар батлагдсан. Тухайлбал: Жилийн 50 сая, 300 сая, 300 саяас -1.5 тэрбум хүртэлх борлуулалтын орлоготой ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн тайлан гаргах хугацаа, татвар ногдуулах орлогын хувь хэмжээнд саналаа тусгуулсан болно. УИХ-аар 2019 оны 3 дугаар сард баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.1.4 заалтад “ноос, ноолуур”-ыг нэмж оруулсан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь ноос, ноолуурын үйлдвэрүүдэд ялангуяа кластераар ажиллаж буй үйлдвэрүүдэд татварын таатай орчныг бий болгож байна.	100	
		4.1.4. Зээлийн батлан даалт, хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг сайжруулах.	эрх зүйн акт-1	2018	Санхүүгийн түрээс, зээлийн батлан даалт, хөрөнгийн барьцааны эрх зүйн орчин хангалтгүй	Санхүүгийн түрээс, зээлийн батлан даалт, хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг сайжруулах.	ХХААХҮС-ын 2019 оны 119 дүгээр тушаалаар баталсан “ЖДҮХС-аас олгох урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын 3.4-т Сангаас зээл олгох тохиолдолд зээлийн эрсдэлийн болон хөрөнгийн даатгалд жил бүр заавал хамруулахаар тусгав. Үүнд: Сангаас шууд олгох зээлийн эрсдэлийн болон барьцаа хөрөнгийн даатгалын үйлчилгээг үзүүлэх даатгалын байгууллагыг сонгох ажлыг зохион байгуулж хамтарсан даатгалын гэрээнд оролцогчид болон Монгол даатгал ХХК, Хаан даатгал ХХК-иуд шалгаран 16	70	

							<p>төслийн 905,0 сая төгрөгийн зээлийг даатгалд хамруулсан.</p> <p>Сангийн яам: Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг 2012 онд батлуулж, тус сангийн Удирдах зөвлөлд СЯ, ХХААХҮЯ, Монголын банкны холбоо, МХАҮТ, МАОЭХолбооны төлөөлөл ажиллаж, барьцаа хөрөнгийн дутагдалтай ЖДҮ эрхлэгчдэд зээлийн батлан даалт гаргах үйл ажиллагаатай холбоотой дотоод, дүрэм журмыг батлуулах, сангийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.</p> <p>АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Зээлийн батлан даалтын тогтолцоог бэхжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх төслийг хэрэгжүүлж, зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд 60 хүртэл хувийн батлан даалттай, зах зээлийн хүүгээс 5-6 хувийн бага хүүтэй зээлийг арилжааны банкаар дамжуулан олгуулах төслийг хэрэгжүүлж байна.</p>		
		4.1.5.Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих эрх зүйн орчинг сайэруулах.	Хууль-1, Хөтөлбөр-1	2018-2020	Хуулийг шинэчлэн боловсруулах шаардлагатай.	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хуулийг боловсруулж, УИХ-аар батлуулсан байх, Хөтөлбөрийн боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар	<p>Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийг 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж батлав.</p> <p>Хуулинд үйлчлэх хүрээг илүү нарийвчлан тогтоож, иргэнийг хасаж, санхүүжилтийг өөр зорилгоор зориулалт бусаар ашигладаг байдлыг хязгаарлах,</p>	100	

						<p>аар батлуулсан байх.</p> <p>ажил олгогч нарын ажлын байр шинээр бий болгор сонирхлыг эдийн засгийн хөшүүрэг ашиглан нэмэгдүүлж, ажилчдын тоо өсөх тусам ЖДҮХС-аас болон банкаар дамжуулж олгох зээлийн хэмжээ нэмэгддэг байх, жил бүрийн улсын төсвийн нийт хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг жижиг, дунд бизнес эрхлэхэд зориулж ЖДҮХС-аар төвлөрүүлэхээр зохицуулсан зохицуулалтыг тусгасан.</p> <p>ЗГ-ын 2019 оны 156 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-ийг батлуулав. Хөтөлбөрт бизнесийн орчинг шинэчлэх, санхүүгийн хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх, бизнес хөгжүүлэх, зөвлөх үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх замаар бизнес эрхлэгчдийг чадавхижуулах, инноваци болон техник технологийг сайжруулах, зах зээлд нэвтрэх, борлуулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” аяныг орон даяар нэвтрүүлэх зэрэг асуудлуудыг тусгасан. ЖДҮ-ийн санхүүжилт, дэмжлэгийн эх үүсвэр, хүртээмжийг нэмэгдүүлэх, үр өгөөжийг сайжруулах зорилгоор бүсчлэн хэлбэрээр Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тэргүүлэх чиглэлийг ЗГ-ын 2019 оны 190 дүгээр тогтоолоор батлуулав. Мөн 418 дугаар тогтоолоор “Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр”, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийг 362 дугаар тогтоолоор батлуулав.</p>		
--	--	--	--	--	--	---	--	--



		4.1.6. Үйлдвэрлэл, худалдааг дэмжсэн хууль, эрх зүйн актыг шинээр боловсруулж батлуулах.	Үндэсний хөтөлбөр-1	2016-2018	Орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурласан боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай	"Үйлдвэр-жилт 21:100" үндэсний хөтөлбөрийг боловсруулж ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна.	ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоолоор батлуулсан. "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөрийн 2019 оны жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий дундаж 76.4 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэсэн үнэлгээгээр дүгнэгдэв. Шалгуур үзүүлэлтийн биелэлтийг авч үзвэл: -Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь 33.3, -Арьс ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 11.1, -Ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 26.0 хувиар, -Хүн амын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулж нийлүүлсэн мах, сүүний үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ 3.3-88.8 хувиар тус тус өссөн дүнтэй байна. -Шинээр байгуулагдсан үйлдвэр: ЗГ-ын 36 дугаар тогтоолын хавсралтад батлагдсан үйлдвэрээс бүрэн ашиглалтад орсон 42, бүтээн байгуулалтын ажил хийгдэж буй 19, нийт 61 үйлдвэр бий болсон. Хөтөлбөрийн 5.4-т "Хөтөлбөр хэрэгжих явцад улсын болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин зэргээс шалтгаалан үр ашиг, ач холбогдол бүхий шинээр байгуулсан үйлдвэрийг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйлдвэрийн тоонд тооцож болно" гэж заасны дагуу ЖДҮХС, ОНХС, гадны хөрөнгө оруулалтаар 11 үйлдвэр	100	
--	--	--	---------------------	-----------	--	---	---	-----	--

							ашиглалтад орж, нийт 72 үйлдвэр 2018-2019 онд байгуулагдсан байна. Ажлын байр 3700-аар нэмэгдсэн.		
			Хөтөлбөр-1	2016-2018	Дунд хугацаанд эдийн засагт бүтцийн өөрчлөлт хийж, тогтвортой өсөлтийг хангах зорилгоор хөтөлбөр боловсруулах шаардлагатай	“Ноолуур” хөтөлбөрийг боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна.	ЗГ-ын 2018 оны 47 дугаар тогтоолоор батлуулсан. Ноолуур” хөтөлбөрийн 2019 оны жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий дундаж 78.1 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээгээр дүгнэгдэв. ХХААХҮЯ-наас бодлогоор дэмжиж МУХБ-тай хамтран ажиллаж, гэрээ байгуулснаар ноолуурын үйлдвэрлэлийг дэмжихээр эргэлтийн хөрөнгийн 86.9, АХБ-наас хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслөөс 8.2 тэрбум төгрөгийн зээл олгосноор самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 40.0, ээрэх үйлдвэрлэлийнх 35.0, сүлжих үйлдвэрийн хүчин чадал 60.0 хувиар тус тус өсч, ажлын байрны тоо өмнөх оны хэмжээнд байна. Ноолуур боловсруулах салбарын түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 25.2 хувьд хүрч, суурь онтой харьцуулахад 36.0%-д хүрч, 3 дахин өссөн байна. 2019 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 700 тн самнасан ноолуур, 100 тн ээрмэл утас гаргах хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийг суурилуулсан. “Монголын хаан ширхэгт” тохирлын баталгаатай ноолууран	100	

							бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах эхлэл тавигдсан. Засгийн газрын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 343 дүгээр тогтоолоор “Хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт нийлүүлсэн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох” журмыг шинэчлэн батлуулсан. Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшинг ахиулах, угаасан ноолуурын экспортыг багасгах зорилгоор “Ямааны ноолуурын үйлдвэрлэл худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулан, Яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлээд байна.		
			Эрх зүйн акт-1	2016	Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сантай холбоотой журам боловсруулах шаардлагатай.	Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна.	Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар “Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан”-г татан буулгах шийдвэр гарсан, мөн Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг УИХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хүчингүй болгосон тул журам боловсруулах эрх зүйн үндэслэл үгүй болно.	ҮБ-гүй	
	<b>Зорилт 4.1-ийн хэрэгжилт</b>	Хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр харьцангуй ахиц гарсан. Тухайлбал: Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хууль, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр, Хүнд үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрүүдийг боловсруулж батлуулсан. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр дүнд ХШҮ хийхэд эхний шатанд хэрэгжүүлэх зорилтот түвшин биелэгдэх боломжтойг харуулж байна. <b>Хэрэгжилт 85%</b>							
	4.2.Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, орон зайн горимыг тодорхойлж,	4.2.1.“Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс”-ийг тодорхойлж батлуулах,	Бодлогын баримт бичиг-1	2016-2019	“Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс” тодорхойлогдоогүй	“Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс”-ийг тодорхойлсон баримт бичиг батлагдсан байна.	ҮХГ-аас аж үйлдвэрийн салбарын нэгдсэн төлөвлөлт байршил, хөгжлийн судалгаа хийлгэхээр ажлын даалгаврыг боловсруулан ажиллаж байна. Монгол Улсын хүнд үйлдвэржилтийн газрын зургийг	70	

	<p>үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоох, Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал боловсруулах, салбарын мэдээллийн тогтолцоог сайжруулах</p>						<p>боловсруулах зорилгоор УУХҮЯ, ХХААХҮЯ, АМГТГ, Мэргэжлийн зөвлөх, эрдэмтэн, судлаачдын төлөөллийг оролцуулсан Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/60 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг нь мэргэжлийн зөвлөх багтай хамтран ажиллаж, “Монгол Улсын хүнд үйлдвэрлэлийн бүс”-ийг боловсруулсан. Хүнд үйлдвэрлэлийн бүсийн талаар бүх яамдаас санал авч, ажлыг эцсийн байдлаар 2017.11.15-ны өдөр зөвлөх багаас хүлээн авсан.</p>		
		<p>4.2.2. “Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс”-тэй уялдуулан үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоох;</p>	<p>Бодлогын баримт бичиг-1</p>	<p>2016-2020</p>	<p>Үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоогоогүй</p>	<p>“Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс”-тэй уялдуулан үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоосон байна.</p>	<p>Аж үйлдвэрийн цахим мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн Монгол Улсын аж үйлдвэржилтийн хөгжил, байршлын орон зайн нэгдсэн төлөвлөлт, зураглалыг ArcGIS программ дээр боловсруулж Монгол Улсын хөдөө аж ахуйн үйлдвэр технологийн паркийн оновчтой байршлыг тодорхойлсон. ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1 заалтад Монгол улсын Үйлдвэржилтийн газрын зургийг эко систем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан гаргах. гэж заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Үйлдвэржилт-21:100” үндэсний хөтөлбөрийн хүрээнд шинээр байгуулах үйлдвэрүүдийн байршлыг нөөц, зах зээлтэй нь уялдуулан хүчин чадлыг тогтоож,</p>	<p>100</p>	

							<p>Үйлдвэржилтийн зураглал гаргав. Хөтөлбөрийн хүрээнд 61 үйлдвэр байгуулагдан үүнээс 42 үйлдвэр нь ашиглалтад орж үйл ажиллагаа явуулж байна.</p>		
		4.2.3. Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх	Мэдээллийн сан-1	2016-2018		5%	100%	100	<p>Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн нэгдсэн сан болох <a href="http://www.industry4.nda.gov.mn">www.industry4.nda.gov.mn</a> цахим системд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх ажилд дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж ажилласан. Тус мэдээллийн систем олон нийтэд нээлттэй бөгөөд Оюу Толгой ХК үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж тус цахим системд бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. ҮХГ нь МОН ТА-9371:“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх төсөл”-ийг 2018.03.13-2019.12.06-ны өдрийг хүртэлх хугацаанд АХБ-тай хамтран амжилттай хэрэгжүүлсэн. Аж үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн сангийн системийг уг төслийн системтэй холбож хөгжүүлэлтийг хийсэн. Тус мэдээллийн системийн бүтэц нь:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Орон нутгийн хөгжлийн индекс /<a href="http://ldi.nda.gov.mn/">ldi.nda.gov.mn/</a></li> <li>2. Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн систем /<a href="http://industry4.nda.gov.mn/">industry4.nda.gov.mn/</a></li> <li>3. Судалгаа шинжилгээний мэдээллийн систем /<a href="http://development.gov.mn/">development.gov.mn/</a></li> </ol>

							4. Төсөл хөтөлбөрийн мэдээллийн систем /development.gov.mn/ 5. Бодлогын баримт бичгийн мэдээллийн систем /development.gov.mn/ Эдгээр таван системийг холбосон Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн платформыг үүсгэн байгуулаад байна. 2019 оны байдлаар 3647 үйлдвэрийг бүртгээд байна.		
	<b>Зорилт 2-ын биелэлт</b>	Аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, орон зайн горимыг тодорхойлж, үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоох, Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал боловсруулах, салбарын мэдээллийн тогтолцоог сайжруулах чиглэлээр тодорхой ажлууд хийгдсэн байна. <b>Хэрэгжилт 80%</b>							
Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэх, Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх, Бүтээмжийг нэмэгдүүлж,	4.3 Бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тогтоон, үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратегийг боловсруулан, үйлдвэрийн /кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх;	4.3.1. Үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратеги"-ийг боловсруулж батлуулах	Бодлогын баримт бичиг-1	2019-2020	Стратеги болон бодлогын баримт бичиг батлагдаагүй	Үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратеги"-ийн бодлогын баримт бичиг баталсан байна.	“Могол ноос” ХХК нь кластераар ажиллан ноосон пальтоны үйлдвэрийг ашиглалтад оруулан шинээр 34 ажлын байр бий болж 2019 онд 2903 ширхэг пальтог Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, Төв, Увс, Баян-Өлгий, Дундговь, Сэлэнгэ аймагт байгуулсан нэрийн барааны борлуулалтын цэгээр борлуулж, “МОГОЛ” брэндийг ОХУ, Унгар улсын зах зээлд худалдаалж эхэллээ. Ээрмэл утасны үйлдвэрийг түшиглэн Алтанбулаг, Баянхангай, Баяндэлгэр, Баянцогт, Баянчандмань, Өндөрширээт, Бүрэн, Зуунмод, Сэргэлэн, сумдын 11 цех ноосон цамц, майк, өмд, ороолт зэрэг 3500 ш бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлсэн байна. Монголын худалдааг дэмжих зорилгоор EU TRAM төслийн хүрээнд байгалийн гаралтай гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниуд болон	70	

<p>арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх.</p>						<p>нэмүү өртгийн сүлжээний 15 байгууллага нэгдэн, Монголын гоо сайхны кластер ТББ байгуулан, монголын гоо сайхны бүтээгдэхүүний хууль эрх зүйн орчинг сайжруулах, дотоод гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах, нэмүү өртгийн хамтын ажиллагааны платформ бий болгох зорилготой.</p> <p>Арьс ширний Хос Аз ХХК, Натурал Лидэр ХХК, Их Эргэлт ХХК, Марал Дизайн ХХК-иуд боловсруулах үйлдвэр болох Их Эргэлт ХХК-иас түүхий эдээ авч Марал Дизайн ХХК, Натурал Лидэр ХХК, Хос Аз ХХК-иуд Марал, Хур, Хос Аз зэрэг арьсан цүнх, жижиг эдлэл, гутлын брэндүүдээ үйлдвэрлэн кластерын хэлбэрээр хоршин ажиллаж олон улсын зах зээлд амжилттай нэвтрэх боломж байгааг харууллаа.</p> <p>Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, экспортод гаргах Дархан арьс ширний цогцолбор/кластер/ байгуулах, түүнд шаардагдах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг судлах Ажлын хэсэг Засгийн газрын 2019.08.06-ны 102 дугаар тогтоолоор батлуулан, Засгийн газрын тогтоолын 2019 оны 226-р тогтоолоор батлуулан гаргасан.</p>		
		<p>4.3.4.Хөнгөн үйлдвэрийг кластераар хөгжүүлж, өрсөлдөх чадварыг</p>	<p>Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь</p>	<p>2016-2020</p>	<p>Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэл-лийн эзлэх хувийн жин 9%</p>	<p>Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийг нэмэгдүүлсэн байна.</p>	<p>100</p>	<p>Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь суурь түвшин/2016/-тэй харьцуулахад 33.3 хувь, арьс ширний үйлдвэрлэлийн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин</p>

		дээшлүүлэн бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь, хэмжээг нэмэгдүүлэх;					11.1 хувь, ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бүрэн боловсруулалтын түвшин 26 хувиар тус тус нэмэгдсэн байна.		
		4.3.5.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн чанар, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулан, ногоон технологид суурилсан экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;	Бэлтгэн нийлүүлэлтийн цогц тогтолцоо-1	2017-2020	Түүхий эдийн гарал үүсэл тодорхойгүй, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо оновчгүйгээс түүхий эдийн чанарт муугаар нөлөөлж байна.	Түүхий эдийн бэлтгэн нийлүүлэл-тийн цогц тогтолцоо бүрдсэн байна.	Мал, мах бэлтгэн нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд нэмүү өртгийн сүлжээ, мөшгих тогтолцооны загвар арга хэмжээг Малын генетик нөөцийн тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчлийн тухай хууль тогтоомжийн хүрээнд дараах чиглэлд зохион байгуулав. Үүнд: 1.Мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан малыг бэлтгэх, хянах, баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, 2.Бэлтгэсэн малыг стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан мах төхөөрөх үйлдвэрт нийлүүлэх, нядалгааны үеийн гэмтэлгүй, тордолт хийсэн арьс ширийг үйлдвэрт нийлүүлэх, 3.Гарал үүсэл нь баталгаажсан махыг хүнсний томоохон сүлжээ дэлгүүр, худалдааны төв, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт хийдэг сургууль, цэцэрлэгт нийлүүлэх ажлыг зохион байгуулав. Загвар арга хэмжээнд Мах импекс, Мах маркет, Эрдмийт, Дархан meat фүүдс, Булган мах маркет, Баяндэлгэр хүнс гэсэн махны	100	



						<p>Үйлдвэр, Хатант Интернэшнл, Дархан нэхий ХК, ДЦС-4 ТӨХК, Номадс сүлжээ ресторан, 58 дугаар сургууль, E-mart, Номин, Лавай сүлжээ дэлгүүр зэрэг аж ахуйн нэгж байгууллагууд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд нэгдэж хамтран ажиллав. “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор батлуулж, тус хөтөлбөрийн 3.3.13-т “мал төхөөрөх үйлдвэрлэл эрхлэх асуудлыг аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрлөөр зохицуулах асуудлыг судалж шийдвэрлэх” заалтыг тусгуулсан. Энэ заалтын хүрээнд Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах санал бэлтгээд байна.</p>		
	4.3.6. Аж үйлдвэрийн салбарын тээвэр, логистикийн сүлжээг хөгжүүлэх;	Нэгдсэн сүлжээний зураглал	2016-2020	Улсын хэмжээнд дэд бүтэц, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ байхгүй.	Аж үйлдвэрийн салбарын тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээ хөгжих боломж бүрдсэн байна.	<p>ХАА-н биржээр арилжих бараа, түүхий эдийн нэр төрлийг ХХААХҮ-ийн сайдын тушаалаар баталдаг бөгөөд одоогийн байдлаар 8 нэр төлийн түүхий эдийг тус биржээр арилжиж байна. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 5.1.7-д заасны дагуу арьс ширийг биржээр арилжихаар Биржийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/19 тоот тушаал гарсан. Үүний дагуу Биржийн Төлбөр тооцоо, логистикийн журамд нэмэлт өөрчлөлт оруулж, мөрдөн ажиллаж байна. Энэ хүрээнд Биржийн үйл ажиллагааг өргөжүүлэх, технологийн шинэчлэл хийх зорилгоор</p>	40	

							Блокчэйн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны платформ нэвтрүүлэх ажлыг санаачлан ТУЗ-ийн хурлаар шийдвэр гаргуулан 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, “Айтүүлс” ХХК тендерт шалгарч, энэхүү ажлыг бүрэн хийж хүлээлгэн өглөө. 2017 онд ҮХГазар, “Ложистикийн холбоо” ТББ хамтран Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Минис төслийн хүрээнд уул уурхайн салбарын тээвэр логистикийн нөхцөл боломжийн судалгааг хийлгэж хүлээн авсан.		
	4.3.7. Чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, шинжлэх ухаан технологийн парк, хүнд аж үйлдвэрийн цогцолборуудын инженерийн дэд бүтцийг цогцоор нь барих үйл ажиллагааг	үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц-1	2016-2020	ШУ-ны парк, Аж үйлдвэрийн цогцолбор, ҮТП-уудын инженерийн дэд бүтэц, ТЭЗҮ-ийн шинэчилсэн судалгаа хийх шаардлагатай байна.	ШУ-ны парк, Аж үйлдвэрийн цогцолбор, ҮТП-уудын инженерийн дэд бүтцийг барьж байгуулсан байна.	Налайхын “Барилгын материалын ҮТП-ийн бүтээн байгуулалтад 2014-2018 онд нийт 6.3 тэрбум төгрөгийг зарцуулж, дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. ЗГ-ын 2011 оны 104 дүгээр тогтоолын “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу өндөр технологи нэвтрүүлсэн, байгаль орчинд ээлтэй 21 аж ахуйн нэгжтэй үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулж 6 үйлдвэр бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлэн ажиллаж байна. Паркийн анхны нэгжээр орсон үйлдвэр “Пийс стийл групп” ХХК-д Налайх дүүргийн 28 иргэнийг ажиллуулж байна.	40	Санхүүжилтын асуудал бүрэн шийдэгдэж чадахгүйгээс шалтгаалж үйл ажлын явц удаашралтай байна.	

							<p>Тайлант 2019 онд авто замыг барьж байгуулах 1.5 тэрбум төгрөгийн/НЗД-ын/ санхүүжилт шийдвэрлэгдэж, одоогоор авто замын зорчих хэсэг болон явган хүний замын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай хийгдсэн. Паркийн үндсэн цахилгаан хангамжийн эхний ээлжийн 110 кв-ын дэд станц, удирдлагын байрыг барих 3,2 тэрбум-1.0 төгрөгийн сонгон шалгаруулалт 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдөр зарлагдсан боловч тендер шалгаруулалтын хүчинтэй хугацаа дууссан учир дахин 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр тендер зарлагдан “Хасу эрчим” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын гүйцэтгэл 20 хувьтай.</p> <p>Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн ҮТП -ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил хөрөнгө оруулалтгүй, ТЭЗҮ олон улсад хүлээн зөвшөөрөгдөхгүй байгаа шалтгаанаас тус паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг улс, нийслэлийн төсөв, гадаад зээл тусламжаар эхлүүлэх талаар судалж санал боловсруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг НЗД-ын 2019 оны А/962 дугаар захирамжаар баталсан. Үүний дагуу Дэлхийн банк менежментийн зөвлөгөө өгөх чиглэлээр хамтран ажиллаж байна. Ингэснээр олон улсын жишигт нийцсэн ТЭЗҮ-тэй болж олон улсаас хөрөнгө оруулалтын</p>	
--	--	--	--	--	--	--	--	--

							мөнгийг босгох нөхцөл бүрдэнэ. 2019.12.05-нд НЗД-ын А-1285 тоот захирамжаар тус паркийн төслийн магадлан шинжилгээ, байгаль орчны үнэлгээ хийх зориулалтаар 400 сая төгрөгийн эрхийг Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ эрх нь шилжсэн.		
		4.3.8. Үйлдвэрлэлийн технологи, дэд бүтцэд ногоон эрчим хүч ашиглах, хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж, дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжих.	Шинэ технологи-1	2016-2020	Үйлдвэрлэлийн технологи, дэд бүтцэд ногоон эрчим хүч ашиглах, хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж, дахин ашиглах технологи нэвтрүүлэлт хангалтгүй	Шинэ технологи нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна.	Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн усыг ариутгах татуургын технологийн хэрэгцээнд, суултуур зайлах, нүүрс угаах, зам, талбайн тоос дарах зэрэг арга хэмжээнд ашиглахаар “Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага MNS 6734:2018 стандартыг мөн цэвэрлэх байгууламжийн усалгаанд ашиглахаар MNS ISO 16075-3:2018 багц стандартыг СХЗГ-аар 2018 онд батлуулж, мөрдөн ажиллаж байна. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх бохир усны стандартыг хангуулахаар арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн хаягдал бохир усыг урьдчилан цэвэрлэх ажил дээр (SECiM)” төслийн хүрээнд НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллагаас ирсэн олон улсын байгаль орчны аудитортай хамтран уг урьдчилан цэвэрлэх байгууламж болон арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд богино хугацааны үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргаж, холбогдох яам, агентлагууд, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд хүргэв. Арьс ширний	40	

							үйлдвэрт олон улсын тэргүүний технологи нэвтрүүлэх чиглэлээр гадаад, дотоодын экспертүүдийг ажиллуулан, харьцуулсан судалгаа хийж, сертификатжуулах чиглэлээр сургалт явуулж байна.		
<b>Зорилт 4.3.-ын хэрэгжилт</b>		Дүгнэлт: Санхүүжилтын асуудал бүрэн шийдэгдэж чадахгүйгээс шалтгаалж үйлдвэрлэл технологийн даркийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааны явц удаашралтай байна. <b>Хэрэгжилт 65%</b>							
	4.4.Дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан боловсруулах, дахин боловсруулах үйлдвэрүүдийг санхүүгийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	4.4.1.Инноваци, өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих	Төсөл-1	2018-2020	Аж үйлдвэрийн салбарын бүтэц уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдэд тулгуурласан хялбар технологи дээр суурилсан ба экспортын бүтээгдэхүүний 95 орчим хувь нь анхан шатны боловсруулалт хийсэн байна.	экспортын бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний эзлэх хувийн жинг нэмэгдүүлсэн байна.	Монгол дахь НҮБ-н Хөгжлийн Хөтөлбөрийн Идэвхжсэн-2030 залуучуудын төсөл, Нийслэлийн ШУҮЙГ-тай хамтран Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ) дээр тулгуурласан "Нийгмийн Энтрепренершип Хөтөлбөр"-ийг 3 сарын турш хэрэгжүүлсэн. "Нийгмийн Энтрепренершип Хөтөлбөр"-г оролцсон багуудаас 2019 оны Үндэсний Аварга"-ыг шалгаруулах арга хэмжээ 2019.12.13-ны өдөр зохион байгууллаа.Хөтөлбөрт амжилттай, тууштай оролцсон багуудад 2020 онд Малайз улсад болох бүсийн залуучуудын нийгмийн энтрепрершипийн чуулганд Монгол улсаа төлөөлөн оролцож өөрийн байгууллагаа олон улсын зах зээлд гаргах, өөр олон олон чуулган, арга хэмжээнд танилцуулан оролцох боломжийг олгосон. ХХААХҮ-ийн Сайдын 2017 оны А-36 дугаар тушаалаар баталсан “Салбарын судалгаа, хөгжлийн ажилд грант олгох журам”-д заасны дагуу Сайдын нэрэмжит Грантын шалгаруулалт зохион байгуулсан. Грант горилж	70	

						<p>ирүүлсэн бүтээлүүдийг Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн 2019 оны хуралдаанаар хэлэлцэн салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх ач холбогдол бүхий, инновацийн чиг баримжаатай нийт 5 төсөл шалгаруулж, ХХААХҮ-ийн Сайдын “Судалгааны ажилд инновацийн грант олгох тухай” 2019 оны А-315 дугаар тушаалаар грантыг олгов</p> <p>БСШУЯ-наас инновацийн сангийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор 2019.11.22-ны өдөр БСШУЯам, ХХААХҮЯам, ҮХГ, ОӨГ, МУИС-иас хамтран зохион байгуулсан “Монголын энтрепренерүүдийн нэгдсэн чуулган 2019” арга хэмжээнд төсөл хэрэгжүүлэгч нарыг оролцуулан, дээрх сангаас дэмжлэг авсан 17 төслийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах үзэсгэлэнг зохион байгуулсан.</p> <p>Тус сангаас 2019 онд инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд гаргах, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нутагшуулах зорилгоор инновацийн 5 төсөлд 300 сая төгрөгийн грант, судалгаа боловсруулалтын ажлын үр дүнг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох чиглэлээр технологийн туршилт, зүгшрүүлэлтийн 18 төсөлд 300 сая төгрөгийн санхүүжилт олгож, төрөөс дэмжлэг үзүүлээ.</p>		
--	--	--	--	--	--	--	--	--

		4.1.2. Төр болон шинжлэх ухаан, боловсрол, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжиж, экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.	Инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2016-2020	Экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд төр болон шинжлэх ухаан, боловсрол, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа холбоо сул байна.	Төр болон шинжлэх ухаан, боловсрол, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдааг сайжруулсны үр дүнд экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэн байна.	ХХААХҮЯ-ны захиалгаар, ШУТС-ийн санжүүжилтээр 2019 оноос ХААИС-ийн бүрэлдэхүүн сургууль болон харьяа 4 ЭШХ-нд Шинжлэх ухаан, технологийн 7 төсөл, ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль түүний харьяа Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнд 1 төсөл хэрэгжиж эхэлсэн. Дээрх шинжлэх ухаан, технологийн 8 төслийг хэрэгжүүлэхэд Шинжлэх ухаан, технологийн сангаас нийт 813.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдэх бөгөөд захиалагч, санхүүжүүлэгч, гүйцэтгэгч нар 3 талт гэрээ байгуулан ажиллаж байна. "Бөсгөсөн шохой - инновацийн бүтээгдэхүүн" судалгааны ажлыг хийж MNS 6738:2018 стандартын гидратын шохой гарган авсан нь арьс ширний салбарт нэвтэрч эхлээд байна. Ингэснээр үйлдвэрүүдийн урьдчилан цэвэрлэх байгууламжид нийлүүлэх лагийн хэмжээ багасч байна. Урьдчилан цэвэрлэх байгууламжийн бохир ус саармагжиж, лагийн үнэр дарагдах зэрэг үр дүнгүүд гарч байна. Монгол дээлийг инновацийн бүтээгдэхүүн болгож буй "Хадлан" дээлийн загварыг сурталчлан танилцуулж, гадаад зах зээлд үйлдвэрлэн гаргаж байна. Монгол уламжлалт гэрийн ерөнхий архитекторыг орчин үеийн майхан хэлбэрт оруулан инновацийн бүтээгдэхүүн болгон,	100	
--	--	--	------------------------------------	-----------	--	--	---	-----	--

							<p>гадаад зах зээл дээр хөрөнгө оруулах маркетинг хийж, бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж буй “Гэр тенд” ХХК экспортын үйлдвэрлэл явуулж эхлээд байна. ЗГ-ын 2019 оны 448 дугаар тогтоолоор "Гаалийн татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодисын жагсаалт"-ыг тус тус батлуулсан. Тус жагсаалтад инновацийн төсөл хэрэгжүүлэгч 23 гарааны компани инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай 6 тэрбум 222.9 сая төгрөгийн өртөг бүхий 311 нэр төрлийн тоног төхөөрөмж, түүхий эд материал урвалж бодис хамрагдсан ба эдгээр тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлснөөр инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид 967 сая төгрөгийн татварын хөнгөлөлт эдлэх боломж бүрдэж, төрөөс инновацийн үйл ажиллагаа эрхлэгчдэд үзүүлэх бодит дэмжлэг болно.</p>		
	<b>Зорилт 4-ийн хэрэгжилт</b>	Дүгнэлт: Инноваци, өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн болон дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд өмнөх онтой харьцуулахад тодорхой үр дүнд хүрсэн байна. <b>Хэрэгжилт 85%</b>							
	4.5.Мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх замаар бүтээлч аж үйлдвэрлэлийн	4.5.1.Соёлын салбарын статистикийг нэвтрүүлэх, соёлын	Төсөл-1	2016-2020	Соёлын салбарын статистик үзүүлэлт тодорхойгүй, соёлын	Соёлын болон бүтээлч аж үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр төсөл	Монголын соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх хүрээнд ХХААХҮЯны Хөнгөн үйлдвэрийн газраас монгол үндэсний хувцасны өдөрлөг, бүтээлч ажлын аяныг зохион байгуулав. Уг арга	100	



	салбарыг хөгжүүлж, шинэ чадавх, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох	үйлдвэрлэлийг хөгжүүлэх;			үйлдвэрлэлийн эзлэх хувь хэмжээ бага	хэрэгжүүлсэн байна.	хэмжээний үеэр нийт ажилтан албан хаагчдын дунд “Дээлээрээ гоёцгооё” 7 хоног зохиож, мөн дээлээ өөрөө урлаж өмсдөг иргэнийг шалгаруулах, Шик салонтой хамтран загварын дээлний чиг хандлагын талаар лекц танилцуулга хийсэн. Үндэсний монгол дээлний өдөртэй болох тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан, яамдаас санал авч нэгтгэн хуралдаанаар оруулахад бэлэн болгосон. Монгол дээлийг инновацийн бүтээгдэхүүн болгож буй “Хадлан” дээлийн загварыг сурталчлан танилцуулж, гадаад зах зээлд үйлдвэрлэн гаргаж байна. Монгол уламжлалт гэрийн ерөнхий архитекторыг орчин үеийн майхан хэлбэрт оруулан инновацийн бүтээгдэхүүн болгон, гадаад зах зээл дээр хөрөнгө оруулах маркетинг хийж, бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж буй ГЭР ТЕНД ХХК экспортын үйлдвэрлэл явуулж, гадаад орны захиалга авч үйлдвэрлэж байна.		
	<b>Зорилт 5-ын хэрэгжилт</b>	Дүгнэлт: Үндэсний монгол дээлний өдөртэй болох тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан, яамдаас санал авч нэгтгэн хуралдаанаар оруулахад бэлэн болгосон. Мөн монгол гэрийг майхан хэлбэрт оруулж инновацийн бүтээгдэхүүн болгон, гадаад зах зээл дээр хөрөнгө оруулах маркетинг хийж, бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж, экспортод гаргаж, гадаадын орны захиалгыг авч эхэлсэн байна. <b>Хэрэгжилт 100%</b>							
		4.6.1.Инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, чадавхжуулах тогтолцоог сайжруулах;	Судалгаа	2018-2019	Салбарын инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх чиглэлийн судалгаа	Боловсруулах үйлдвэрийн салбарын инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх чиглэлээр	“Мэргэжлийн боловсрол, сургалт-Ажилсаг Монгол” үндэсний зөвлөгөөнийг Төрийн ордонд зохион байгуулж, Улсын их хурлын гишүүд, элчин сайд, Монголын ажил олгогч эздийн холбоо, МБСБ-ын захирал, багш, гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдийн удирдлагууд,	70	

					<p>судалгааг зохион байгуулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна.</p>	<p>суралцагч, төгсөгчид, холбогдох төрийн болон ТББ-ын төлөөлөл нийт 850 хүн оролцуулав.</p> <p>Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ТНБД-ын А-507 тушаалаар шинэчлэн, ажлын хэсгийн төлөвлөгөө гаргаж батлуулсан.</p> <p>Хэвлэлийн салбарын эрдэмтэн судлаачидтай мэргэжлийн холбоо хамтран хэвлэгч-дэвтэрлэгчийн сургалтыг зохион байгуулж, 42 ажилтанг хамруулсан.</p> <p>Хөнгөн үйлдвэрийн 10 салбарт салбар бүрийн хүний нөөцийн асуудлаар тулгамдаж буй асуудал, гарц шийдэл хэлэлцүүлгийн 2019 оны 10-09-нөөс 10-25-ны хооронд хийж, зөвлөмжийн төсөл бэлтгэн Хөнгөн үйлдвэрийн улсын зөвлөгөөнөөр танилцуулсан.</p> <p>Хөнгөн үйлдвэрийн салбарын ИТА бэлтгэгч ШУТИС-ын БуХУС, ҮТС-тэй хамтран Хөнгөн үйлдвэрлэл хүний нөөц-тогтвортой хөгжил” онол практикийн бага хурлыг зохион байгуулж, их дээд сургуульд бэлтгэгдэж буй мэргэжилтний судалгаа, тогтвор суурьшилтай ажиллах боломж, үйлдвэрлэлийн мэргэжилтний эрэлт хэрэгцээ зэрэг 6 асуудал дэвшүүлсэн илтгэл тавьж, хэлэлцүүлэв.</p> <p>Мөн “Ноолуур” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн суурь судалгааг үндэслэн хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдлын судалгааг хийсэн.</p>	
--	--	--	--	--	---	---	--

						"Ажилсаг монгол" хөтөлбөртэй хөнгөн үйлдвэрийн салбарын хүний нөөцийн эрэлтийн судалгаа, асрамж халамжаас гарч буй залуусыг ажлын байраар хангах зорилтот төслийг хамран зохион байгуулах ажлыг төлөвлөв.			
			сургалт	2018-2020	Мэдлэг, мэргэшлийг дээшлүүлж байх шаардлагатай.	<i>Боловсруулах үйлдвэрийн удирдах болон инженер, техникийн ажилтнуудыг нарийн мэргэжлээр өндөр хөгжсөн оронд давтан сургах, туршилага судлуулах, чадавхижуулах, менежментийн болон технологийн сургалтыг зохион байгуулах</i>	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" төслийн дэмжлэгтэй Турк улсад зохион байгуулагдах "Техникийн текстилийн олон улсын сургалт, хурал"-д 4, БНХАУ-д гутлын үйлдвэрлэлийн чиглэлээр 6 хүнийг хамруулав. Техник Технологийн Дээд сургуулийн харьяа "Монгол Коосэн" Технологийн Коллежийн 10 оюутан Япон улсын үйлдвэр, компанид 1-4 долоо хоногийн дадлага хийж ирсэн. Дэлхийн банкны "Экспортыг дэмжих" төслийн санхүүжилтээр ШУТИС-ийн ҮТИС-ийн Шима Сейки сургалтын төвтэй хамтран Япон улсын Шима Сейки фирмийн сүлжмэлийн машины SDS-ONE APEX-3 дизайн системийн анхан шатны болон ахисан түвшний 2 удаагийн сургалтад ноос, ноолуурын үйлдвэрийн инженер, технологич, программист зэрэг 38 оролцогч хамрагдаж сүлжмэлийн SDS-ONE системийн тохиргоо, цэс, түүл, программ хангамжийн автомат тохиргоо, авто процессын параметрууд, оптик шугам, нэхэх, хянах симуляци, сүлжмэл эдлэл хийх, машин механизм, дэлгэцийн машин засвар үйлчилгээ, сүлжмэлийн программ, бүтцийг бэлтгэх зэрэг мэдлэг эзэмшлээ.	100	

							Мөн төслийн санхүүжилтээр Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж байгаа 12 компанийн хүсэлтээр Штолл фирмийн Хятад дахь албан ёсны төлөөлөгчийн газрын ахлах сургагч багш Яан Зейлянг урьж, 10 өдрийн техникийн түвшний сургалт зохион байгууллаа. Сургалтад эдгээр компанийн машин баригч 12 ажилтан хамрагдаж CMS машины бүтэц зохион байгуулалт, сүлжих, нэхэх технологи, машинд шаардагдах төрөл бүрийн үйлчилгээ, программ хангамжийн асуудлаар онол, практик хосолсон мэдлэг ур чадвар эзэмшиж цаашид ажлын байран дээрээ сургагч багш болох зорилготой юм. Сургалтыг амжилттай төгссөн ажилтнуудад Германы Штолл фирмийн сургалтын гэрчилгээ олгосон.		
	4.6.2. Хөнгөн үйлдвэрийн салбарыг “Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэл”-д оруулж, Засгийн газрын 2014 оны 71-р тогтоолд өөрчлөлт оруулах.	санал	2018-2019	Хөнгөн үйлдвэрийн машин ашиглалтын инженер, Арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийн хими технологи, Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи мэргэжил үйлдвэрлэлд нэн шаардлагатай байгаа ч элсэлт цөөхөн байна. Дээрхи мэргэжлээр суралцагчид мэргэжлээ солих явдал байна.	Хөнгөн үйлдвэрийн машин ашиглалтын инженер, Арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийн хими технологи, Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи мэргэжлээр хангагдах нөхцөл бүрдсэн байна.	ХХААХҮЯ ны ТНБД-ын 2019 оны 05-13 ны 01/1866 албан бичгээр нэхмэлийн болон хөнгөн үйлвэрийн ашиглалтын технологи, хувцас үйлдвэрлэл, ойн инженер, хэвлэл, мод, эко материал боловсруулах 9 мэргэжлийг “тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрийн /мэргэжил/ жагсаалт”-д оруулах, элсэгчдийг тэтгэлэгт хамруулах тухай саналыг БСШУЯ-нд шийдвэрлүүлэхээр хүргүүлэв.	70		

		4.6.3. Ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.	Зохион байгуулсан аян-1	2016-2020	Ажиллах орчин, нөхцөл бүрдээгүй-гээс ажилчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байна. Хөдөөнөөс хот руу шилжилт хөдөлгөөн их байна.	Ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах орчин, нөхцөлийг сайжруулсан байна.	Хот, суурингаас хөдөөд шилжин суурьшиж, мал маллах хүсэлтэй өрхийг цалин хөлстэй ажилд зуучилж, тогтвортой ажлын байр, орлоготой болгох зорилгоор “Тэрээт малчин – өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төсөл”-ийг ХНХС-ын 2018 оны А/206 тоот тушаалаар батлуулан хэрэгжүүлсэн. Говь ХК жилд 2000 тн ноолуур самнах хүчин чадалтай, анхан шатны үйлдвэрийг Төв аймгийн Сэргэлэн суманд байгуулахаар 17 га газар авч, шав тавин энэхүү бүтээн байгуулалтын хүрээнд үйлдвэрийн барилгын ажил 70 хувьтай байна. Мөн ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр 1000 ажилчдын орон сууцыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Хөнгөн үйлдвэрийн салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжоор хангах зорилгоор “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөр боловсруулан батлуулах Ажлын хэсгийг ТНБД-ын А-430 тогтоолоор батлан гаргаж, олон нийтийн болон их дээд сургуулиудын оролцоотой хэлэлцүүлэг 2 удаа зохион байгуулав. Хөтөлбөрийг 2020 оны 2-р улиралд ЗГ-аар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	70	
	<b>Зорилт 6-ын хэрэгжилт</b>	Дүгнэлт: Үйлдвэрийн инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, чадавхжуулах чиглэлээр холбогдох сургалтад хамруулж байгаа хэдий ч системтэй аж үйлдвэрийн салбарын хүний нөөц мэргэжилтний ажилтан бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр “Мэргэжилтний ажилтан” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатайг илтгэн харуулж байна. Хөтөлбөр боловсруулж батлуулах ажил удаашралтай байна. <b>Хэрэгжилт-77.5%</b>							
<b>Хөтөлбөрийн ерөнхий дундаж үнэлгээ-82.1%</b>									